



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2011 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 726

Улаанбаатар хот

Зохистой харьцааг шинэчлэн тогтоож,
журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1."Банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцааны доод хэмжээ"-г энэ тушаалын хавсралтын дагуу шинэчлэн тогтоож, 2012 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2.Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 460 дугаар тушаалаар батлагдсан "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-ын 1.5, 2.1 дэх хэсэгт дараахь заалтуудыг нэмсүгэй:

а)"1.5.24."Банкны системд нөлөө бүхий банк" гэж сүүлийн 6 сарын турш банкны системийн нийт активын 5 хувиас дээш хувийг эзэлж байгаа банкиг хэлнэ." гэж;

б)"2.1.3.Шаардлагатай тохиолдолд Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар системийн нөлөө бүхий банкинд тавигдах нэмэлт өөрийн хөрөнгийн шаардлага" гэж.

3.Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 460 дугаар тушаалаар батлагдсан "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-ын 2.6.1 дэх заалт болон журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийн тайлан"-гийн Б.13, Б.14 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

а)"2.6.1."Банкны тухай хууль"-ийн 16 дугаар зүйлийн 16.3-т зааснаас бусад тохиолдолд банк, банк бус санхүүгийн бусад байгууллагын өөрийн хөрөнгөд шууд болон гуравдагч этгээдээр дамжуулан байршуулсан хөрөнгийн 75 хувийг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс, үлдсэн 25 хувийг хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс тус тус хасна;" гэж;

б) Б.13, Б.14. Засгийн газрын үнэт цаас болон Засгийн газрын баталгаатай үнэт цаас" гэж.

4.Энэ тушаалын 2,3 дахь заалтыг энэ тушаал гарсан өдрөөс эхлэн мөрдсүгэй.

14 1677


5.Энэ тушаал гарсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 460 дугаар тушаалаар батлагдсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 2.6.2, 2.6.3 дахь заалт, 2011 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 356 дугаар тушаалын 1.а заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6.Энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцааны доод хэмжээ”-г заасан хугацаанд хангаж ажиллахыг банкны Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосугай.

7.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Б.Лхагвасүрэн)-т даалгасугай.



Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны
12 дугаар сарын 14 ны өдрийн 746... дугаар
тушаалын хавсралт



БАНКНЫ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ
ХАРЬЦААНЫ ДООД ХЭМЖЭЭ

Огноо	2012 оны 6 сарын 30	2012 оны 12 сарын 31	2013 оны 6 сарын 30
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдлээр жигнэсэн активын зохистой харьцаа	7 хувь	8 хувь	9 хувь
Өөрийн хөрөнгө эрсдлээр жигнэсэн активын зохистой харьцаа	12 хувь	12 хувь	12 хувь
Нэмэлт өөрийн хөрөнгийн шаардлага*	0,5 хувь	1 хувь	2 хувь
Нийт өөрийн хөрөнгө эрсдлээр жигнэсэн активын зохистой харьцаа	12,5 хувь	13 хувь	14 хувь

* - Сүүлийн 6 сарын туршид банкны системийн нийт активын 5 хувиас дээш хувийг бүрдүүлж байгаа банкуудад Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар нэмэлт өөрийн хөрөнгийн хэмжээг тогтооно.

оОо